

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2014 ОНЫ 23 ДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2014 оны наймдугаар сарын 28-ны өдрийн 14 цаг 00 минутад эхэлж, 16 цаг 17 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 17 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн өмчийн хорооны даргын сонгон шалгаруулалтын тайлан, дүгнэлт гаргах, нэр дэвшүүлэх тухай	<p>Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <ol style="list-style-type: none">1. Дашнамжилын Цогтбаатарыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.2. Энэ тогтоолын 1 дэх хэсэгт нэр заасан иргэн Дашнамжилын Цогтбаатарыг Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Төрийн өмчийн хорооны даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Архивын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд

		<p>томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Батцэрэгийн Эрдэнэбадрахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Архивын ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Маналжавын Төрбаярыг Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболдод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	Үндэсний статистикийн хорооны Макро эдийн засгийн статистикийн газрын даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 14-ийн "а"-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны</p>

		<p>шийдвэрийг үндэслэн: Элдэв-Очирын Эрдэнэсанг Үндэсний статистикийн хорооны Макро эдийн засгийн статистикийн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, тус хорооны дарга С.Мэндсайханд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов</p>
5	<p>Цөмийн энергийн газрын Цөмийн технологийн газрын даргад нэр дэвшүүлсэн тогтоолыг хүчингүй болгох тухай</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.1.6 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Засгийн газрын тохируулагч агентлаг Цөмийн энергийн газрын Цөмийн технологийн газрын даргын албан тушаалд томилуулахаар Энхгэрэлийн Нямдаваад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гарган, нэр дэвшүүлсэн “Нэр дэвшүүлэх тухай” Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 86 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох.</p> <p>2.Энэ тогтоолыг Цөмийн энергийн газрын дарга Н.Тэгшбаяр болон нэр дэвшигч Э.Нямдаваа нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	<p>Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны нэрийг нөөцөөс хасах тухай</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.1.6 дахь заалтыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн</p>

		<p>ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нөөцийн жагсаалтаас Сэнгээгийн Буяндалай, Гаваагийн Түвшинбаяр, Сономцэрэнгийн Энх-Амгалан, Сүхбаатарын Чулуунбаатар нарыг хассанд тооцох.</p> <p>2.Энэ тогтоолыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэг болон иргэн С.Буяндалай, Г.Түвшинбаяр, С.Энх-Амгалан, С.Чулуунбаатар нарт хүргүүлэхийг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
7	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны Шүүхийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалын сул орон тоог нийтэд зарлах тухай	<p>Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Т.Мэндсайханы 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 03/1211 тоот албан бичиг, захиалгаар Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу уг ажлын байранд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2014 оны 10 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулахаар тогтов.</p>
8	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирлын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг дахин зарлуулах тухай	<p>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албаны Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирлын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг дахин нийтэд, нээлттэй зарлаж, 2014 оны 10 дугаар сарын 3-ны өдөр зохион байгуулахаар тогтов.</p>

9	Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.2, 1.4, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүний нийтлэг жишиг”, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын “Хоёр”-ын 2. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:</p> <p>4). “Тамгын газрын орлогч дарга” гэснийг “Дэд дарга” гэж,</p> <p>7). “Дотоод хяналтын улсын ахлах байцаагч (Ёс зүйн хорооны дарга)” гэснийг “Санхүү аж ахуйн хэлтсийн дарга” гэж,</p> <p>9). “Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн” гэснийг “Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн” гэж тус тус өөрчлөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
10	Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөлөөс 2014 оны 07 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан төрийн захиргааны удирдах ажилтны 10 ажлын байранд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг эс зөвшөөрч, тус аймгийн иргэн Б.Баянмөнх, Б.Батнасан, О.Өлзийтогтох, Х.Эрдэнэсайхан, Ш.Самбал лхүндэв, Х.Рагчаа нараас гаргасан өргөдлийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн	Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөлөөс 2014 оны 07 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны 10 ажлын байранд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг эс зөвшөөрч тус аймгийн иргэн Б.Баянмөнх, О.Өлзийтогтох, Б.Батнасан, Х.Эрдэнэсайхан, Ш.Самбаллхүндэв, Х.Рагчаа нараас Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг

	<p>тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 3.1-д заасныг удирдлага болгон:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөлөөс 2014 оны 07 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны 10 ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, сонгон шалгаруулалтыг дахин нээлттэй зарлаж явуулах нь зүйтэй гэсэн Маргааны хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх</p> <p>2. 2014 оны 07 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны 10 ажлын байрны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалттай холбогдох Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөлийн шийдвэрийг хүчингүй болгож дахин нээлттэй сонгон шалгаруулалт явуулахыг Салбар зөвлөлийн дарга Г.Төмөрбаатарт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--------------	---

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

